

Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг: Монголд хийсэн айлчлалын урьдчилсан дүгнэлт (2022 оны Аравдугаар сарын 3-14 өдрүүд)

I. Оршил

Монгол Улсын Засгийн газрын урилгаар НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг 2022 оны 10 дугаар сарын 3-14-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Тус Ажлын хэсгийг хатагтай Элина Штайнерте (Латви Улс), ноён Мэттью Гиллетт (Шинэ Зеланд Улс) нар төлөөлж тэднийг НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын ажилтнууд дагалдав.

Энэ нь Ажлын хэсгийн тус улсад хийж буй анхны албан ёсны айлчлал бөгөөд улс орондоо айлчлахыг урьж хамтран ажилласан Монгол Улсын Засгийн газарт Ажлын хэсгийн зүгээс гүн талархалаа илэрхийлж байна. Тухайлбал, Ажлын хэсэг Гадаад Харилцааны Яам, Эрүүл Мэндийн Яам, Хууль Зүй, Дотоод Хэргийн яам, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам, Улсын Ерөнхий Прокурорын Газар, Улсын Дээд Шүүх, Батлан Хамгаалах Яам, Улсын Их Хурлын Хүний Эрхийн Дэд Хороо, Тагнуулын Ерөнхий газар, Хүний Эрхийн Үндэсний Комисс, Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Монголын Хуульчдын Холбоо, Өмгөөлөгчдийн Холбооны албаны хүмүүстэй уулзлаа.

НҮБ-ын Монгол Улс дахь Суурин Зохицуулагч болон тус албаны ажилтнуудад айлчлалыг дэмжиж туслалцаа үзүүлсэнд Ажлын хэсгийн зүгээс талархал илэрхийлж байна. Мөн тус Ажлын хэсэг дур зоргоор хүний эрх чөлөөг хязгаарлах асуудлаар тус улсын олон оролцогч талууд болох иргэний нийгмийн байгууллагууд, хуульчдын төлөөлөлтэй уулзсан бөгөөд санал бодлоо хуваалцаж туслалцаа үзүүлсэн бүх хүмүүст талархаж байна.

Та бүхэнд танилцуулж байгаа энэ ажиглалтууд нь Ажлын хэсгийн урьдчилсан гаргалгаа дүгнэлт гэдгийг юуны өмнө хэлье. Эдгээр ажиглалтаа Ажлын хэсгийн гишүүд дахин хэлэлцэн нягталж нэгтгээд Женевт ойрын хугацаанд болох хуралдаанаар хэлэлцүүлэх илтгэл болгон боловруулах юм. Дараа нь Ажлын хэсэг ажиглалт хийсэн ажлынхаа тайланг гаргаж, эцэслэн баталгаажуулж 2023 оны есдүгээр сард болох НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 54 дүгээр чуулганд өргөн барих юм.

Ажлын хэсэг нь Улаанбаатар хот болон Төв аймгийн хорих ангиуд, цагдаагийн хэсгүүд, эрүүлжүүлэх байрууд, түр хамгаалах байрууд, түүнчлэн Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, Согтуурах, Мансуурах Донтой Өвчтөнг Албадан Эмчлэх Төв, Ахмадын Үндэсний Төв болон Гадаадын Иргэдийг Саатуулах хэсэг зэрэг нийт 21 газарт урдчилан мэдэгдэж болон гэнэтийн байдлаар очиж ажилласан. Эдгээрээс хоёр нь буюу Хүүхэд Хамгааллын Хариу Үйлчилгээ, Түр Хамгаалах Байр болон Батсүмбэрийн Ахмадын Үндэсний Төв нь хүмүүсийн эрх чөлөөгөө хязгаарлуулсан байгууламж биш гэдэг дүгнэлтийг ажлын хэсэг гаргажээ. Ажлын хэсэг эрх чөлөө нь хасагдсан 65 орчим хүнтэй хөндлөнгийн хүнгүйгээр ганцаарчлан ярилцлага хийх боломжоор хангагдаж, очиж үзэхийг хүссэн бүх газраа аливаа хүндрэл саадгүй зохих журмын дагуу нэвтэрч байсан бөгөөд бидэнд энэ бололцоог бүрдүүлж бусдад үлгэр жишээ болохуйцаар хамтран ажилласан Засгийн газарт гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

II. Сайн туршлага, зэрэг өөрчлөлтүүд

Хүний Эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК)

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс нь 2000 онд анх байгуулагдаж, гурван комиссараас бүрдэн ажилласан бөгөөд хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр өргөн чиг үүрэг хэрэгжүүлдэг байна. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг 2020 онд шинэчилэн найруулж өөрчилснийг Ажлын хэсэг тэмдэглэж байгаа бөгөөд уг өөрчлөлтөөр ХЭҮК-ын бүрэн эрхийг өргөтгөсний зэрэгцээ Парисын зарчмуудад нийцүүлэхийг эрмэлзэж буйг тухайлан сайшааж байна. Комиссын

гишүүдийн сонгон шалгаруулалт, томилгоонд шинэчлэлт оруулж үйл ажиллагааг нь ил тод болгох, ХЭҮК-ын жилийн тайланг УИХ-ын чуулганаар сонсох боломжийг бүрдүүлсэн байна. Хуулийн шинэчилсэн найруулгын 26 дугаар зүйлд заасны дагуу заавал дагаж мөрдөх заавар, зөвлөмж гаргах зэргээр ХЭҮК-ын бүрэн эрхийг өргөтгөснийг Ажлын хэсэг онцгойлон сайшааж байна. ХЭҮК-ын шийдвэр, арга хэмжээг тогтоосон хугацаанд биелүүлээгүй холбогдох албан тушаалтныг огцруулах хүртэл арга хэмжээ авах хууль эрхийн үндэслэл бүрдүүлсэн байна. ХЭҮК 2022 он гарсаар ийм төрлийн 17 заавар, 27 зөвлөмж хүргүүлжээ. 2020 оны шинэчилсэн найруулга, мөн 2021 оны 4 дүгээр сард Хүний Эрхийг Хамгаалагчдын Тухай Хууль, 2021 оны 12 дугаар сард Хувийн Мэдээллийг Хамгаалах тухай хуулиудаар Комиссын гишүүний тоо 7 болж нэмэгдсэн бөгөөд Комиссын 3 гишүүн тусгай сэдэвчилсэн багц асуудал эрхлэн ажиллаж байна.

Ажлын хэсэг түүнчлэн ХЭҮК-ын бүрэн эрхээ бие даан, үр дүнтэй хэрэгжүүлэхэд төсөв чухал гэдгийг тэмдэглэж байна. ХЭҮК-ын төсөв улсын нэгдсэн төсөвт тусч, санхүүгийн бие даасан байдлаа бэхжүүлэх хуулийн заалтууд бий болсныг сайшааж байна. ХЭҮК-ын төсвийг үе шаттайгаар нэмэгдүүлж, 2023 онд 4.5 тэрбум төгрөг төсөвлөсөн нь тус хуулийг улсын хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх нь гарцаагүй. Ажлын хэсгээс ХЭҮК-ын чиг үүргийг бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхийн тулд шаардлагатай санхүүжилт, ялангуяа түүнд олгосон шинэ чиг үүргүүдийг цаашид хуваарилан олгохыг санал болгож байна.

Урьдчилан Сэргийлэх Үндэсний Механизм

Монгол Улс Эрүүдэн Шүүхийн Эсрэг Конвенцийн Нэмэлт Протоколыг (ЭШЭКНП) 2015 онд соёрхон баталсан бөгөөд хэдийгээр хожуу ч гэсэн уг конвенцийн дагуу Урьдчилан Сэргийлэх Үндэсний Механизм (УСҮМ) бий болгосныг Ажлын хэсэг талархан сайшааж байна. Монгол Улсын УСҮМ - ын бүрэн эрхийг ХЭҮК-ын тухайлсан ажлыг хариуцсан комиссар хэрэгжүүлэхээр зохицуулсан байна. Энэ нь комиссын бүрэн эрхийн хугацаанд томилогдсон Комиссын гишүүний чиг үүрэгт багтсан байнгын үүрэг бөгөөд уг ажлыг шинээр байгуулагдсан УСҮМ - ын алба хариуцан гүйцэтгэх юм. Тийн хэдий ч уг нэгжийг янз бүрийн салбарын 10 мэргэжилтнээс бүрдүүлэн ажиллуулж төсөв хэмнэх шаардлага тавигдаж байгаа тул эхний хоёр жилийн хугацаанд ердөө таван орон тоотой ажиллахаар байгаа нь бидний санааг зовоож байна.

Түүгээр ч зогсохгүй УСҮМ – ын албаны ажилтнуудыг сонгон шалгаруулахад Төрийн албаны зөвлөл ямар үүрэг гүйцэтгэж байгаа, энэ асуудалд УСҮМ - ын асуудал эрхэлсэн комиссар тун бага эрх мэдэлтэй оролцохоор байгаад Ажлын хэсэг санаа зовниж байна. Ажлын хэсэг УСҮМ – ын бие даан ажиллах чадамжийг хангахын чухлыг онцолж, УСҮМ - ын боловсон хүчнийг сонгохдоо бие даасан байдлыг нь хангаж өгөхийг Засгийн газарт хүсэлт болгож байна. Монгол Улсын газар зүйн байрлалтай уялдан дур зоргоор эрх чөлөөг хязгаарлах зарим газрын алслагдсан байршлаас шалтгаалан УСҮМ - ын албыг яаралтай арван хүний бүрэлдэхүүнтэй ажиллах бололцоог бүрдүүлэх нь маш чухал юм.

УСҮМ - ын албанд ногдох төсвийг ХЭҮК-ын нэгдсэн төсөвт тусгаж өгсөн нь эерэг үзүүлэлт гэдгийг Ажлын хэсэгт тэмдэглэж байна. Гэвч ХЭҮК-ын Тэргүүн комиссар болон Тамгын газрын даргын зөвшөөрөлгүйгээр УСҮМ -ын ажилд зориулагдсан санхүүжилтийг ажил эрхэлсэн Комиссар бие даан захиран зарцуулах бололцоогүй байгаа нь УСҮМ - ыг санхүүгийн бүрэн бие даасан гэж үзэх боломжгүй байдалтай болгож байгаад Ажлын хэсэг ихээхэн санаа зовниж байна. Энэ нь эрх чөлөөгөө хасуулсан газруудад гэнэтийн шалгалт хийх УСҮМ -ын бүрэн эрхэд зайлшгүй шаардагдах ажилд онцгой сөрөг нөлөө үзүүлж байна. Ажлын хэсэг УСҮМ - ыг санхүүгийн хараат бус, ялангуяа гэнэтийн шалгалт хийх бүрэн бололцоо, чадвартай болгохыг Засгийн газарт уриалж байна.

Ажлын хэсэг ХЭҮК, УСҮМ тэдгээр ангиудад очиж ажилладаг талаар мэдээлэл авч байсан бөгөөд энэ нь нэн сайшаалтай хэрэг юм. Ажлын хэсэг эрх чөлөөг нь дур мэдэн хасахаас урьдчилан сэргийлэхэд байнгын хараат бус хяналт чухал үүрэгтэйг тэмдэглэж, ХЭҮК,

УСҮМ - ын чиг үүргээ бие даан, үр дүнтэй хэрэгжүүлэх чадамжийг цаашид бэхжүүлэхийг Засгийн газарт анхааруулж байна. Үүний тулд УСҮМ - ын бүрэн эрхээ үр дүнтэй, бие даан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, түүний мэдэлд байгаа санхүүгийн эх үүсвэрийг цаашид нэмэгдүүлэхийг Ажлын хэсэг анхааруулж байна.

Хүний эрхийг хамгаалагчдыг дэмжих тухайд

Саяхан 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Хүний Эрхийг Хамгаалагчийн Эрх Зүйн Байдлын тухай Монгол Улсын хууль батлагдсанд Ажлын хэсэг талархаж байна. Хуулийн төсөл боловсруулах үйл явцад иргэний нийгмийн оролцоо хүчтэй байгааг тэмдэглэхийн зэрэгцээ хуулийн төсөлд иргэний нийгмээс өгсөн саналыг УИХ – ын Ажлын хэсэг үндсэндээ уг хуулийн төсөлд тусгах боломж нэн хомс болсон шатанд иргэний нийгмээс хүлээн авч багахан хэсгийг нь хуулийн төсөлд тусгасан байна.

Энэхүү хууль нь хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг хүчтэй дэмжих үндэс болжээ. Монгол Улс ардчилсан нийгэмд нэн ач холбогдол бүхий хууль дээдлэх эрх зүйн тодорхой зохицуулалтыг бүрдүүлсэн Азийн анхны улс болж байна. Тус хуулиар Хамгаалах Механизмыг бий болгож, уг механизмын ажлыг зохицуулах чиг үүрэг бүхий ХЭҮК-ын комиссар томилогдон ажиллаж байна. Ажлын хэсэг эдгээр алхмуудыг сайшааж энэ хуулийг бодит амьдрал дээр үр дүнтэй хэрэгжүүлэхийг уриалж байна.

Эдгээрийн зэрэгцээ Ажлын хэсэг хуулийн зарим тодорхой зүйл заалтад ихээхэн санаа зовж байна. Заалт 5.1.5 нь хүний эрхийг хамгаалагчид “бусдын нэр төр, алдар хүндийг... хүндэтгэх”-ийг шаарддаг бөгөөд үүний нэгэн адил Заалт 8.1 нь хүний эрхийг хамгаалагч бусдын нэр төр, алдар хүнд, “... ажил хэргийн нэр хүндийг гутаах”- аар халдахыг хориглохоор заасан байна. Гэтэл хүний эрхийг хамгаалагчдын хууль ёсны ажил нь тухайн цаг үеийнхээ бодлого, үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж, шаардлагатай бол эсэргүүцэх явдал байдгийг тооцвол дээрх бүдэг бадаг, өргөн хүрээтэй үг хэллэгийг мушгин хүний эрхийг хамгаалагчдын амыг таглан, улмаар гэмт хэрэгт тооцож ч болзошгүй юм.

7-р зүйлд “... үндэсний эв нэгдлийг бусниулах, ... террорист болон экстремист” үйл ажиллагаа явуулж буй байгууллага, хүн гэх мэт этгээдээс санхүүжүүлэхийг хориглох замаар хүний эрхийг хамгаалагчдын авч болох нөөцийг хязгаарласан. Энэ заалтыг маш өргөн хүрээнд авч үзвэл хүний эрхийг хамгаалагчдын амин чухал үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэрийг хязгаарлахад ашиглагдаж, улмаар хүний эрхийг хамгаалагчдын чиг үүргээ хэрэгжүүлэх чадварыг үндсээр нь сулруулж болно.

Хүний эрхийг хамгаалагчийг үйл ажиллагааг нь үндэслэн цагдан хорьж байгаа нь Түгээмэл тунхаглалын 7 дугаар зүйл, Пактын 26 дугаар зүйлд заасан хуулийн өмнө эрх тэгш байх, хуулиар тэгш хамгаалагдах эрхийг зөрчиж байгааг Ажлын хэсэг анхааруулж байна. Хүний эрхийг хамгаалагчийн статус нь Пактын 26 дугаар зүйлд заасны дагуу хамгаалагдсан статусуудын нэг байдаг.

Өршөөлийн тухай хууль

Ажлын хэсэг сүүлийн 10 жилд батлагдсан Өршөөлийн тухай хэд хэдэн хууль, 2021 оны Ардын хувьсгалын 100 жилийн ойгоор батлагдсан Өршөөлийн тухай хуулийн талаар мэдээлэл авсан. Энэ хуулийн дагуу 2000 орчим хоригдол суллагдсан буюу ялаа хөнгөрүүлсэн нь эерэг үзүүлэлт юм. Мөн өршөөлд хамрагдаагүй хэд хэдэн этгээд уг өршөөлөөс гадуурхагдсантай холбогдуулан ХЭҮК эсэргүүцэн өршөөлд хамруулахаар амжилттай ажилласныг Ажлын хэсэг сайшааж байна. 2021 онд батлагдсан уг Өршөөлийн хуульд онц хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хүмүүс өршөөлөөс хасагдсан байгаа бөгөөд цаашид хоригдол бүрийг өршөөлийн хуульд хамруулж байхыг Ажлын хэсэг Засгийн газарт уриалж байна.

Цагаачлалтай холбогдуулан цагдан хорих, саатуулах тухайд

Цагаачлалтай холбогдуулан системчилсэн байдлаар цагдан хорих, саатуулах практик байдаггүйг Ажлын хэсгийнхэн таатай хүлээж авсан. 2022 онд зөвхөн долоон гадаадын иргэн визний нөхцөлөө зөрчсөний улмаас саатуулагдсан болохыг Ажлын хэсэгт мэдээллээ; гадаадын иргэдийг саатуулах төвд ажилтай нь танилцах үед тэнд саатуулагдсан нэг ч хүн байгаагүй. Гадаадын иргэдийг, ялангуяа гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхдүүдийг саатуулахгүй байх чиглэлтэй байгаа нь маш сайшаалтай байлаа. Ажлын хэсэг Засгийн Газраас цагаачлалтай холбогдуулан цагдан хорихгүй байх чиг хандлагаа цаашид баримталж байгааг дэмжихийн сацуу Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн одоогийн мөрдөгдөж буй шүүгчийн захирамжаар 30 хүртэл хоногийн хугацаагаар саатуулж шаардлагатай тохиолдолд 30 хоног бүр хугацааг сунгасаар 6 сар хүртэл саатуулж болох заалтыг шинэчлэн найруулахыг уриалж байна. Зургаан сарын эцэст тухайн хүн суллагдах ёстой ч дахин саатуулах боломжтой бөгөөд хэр удаан хугацаагаар хоригдож болох талаар хязгаарлалт байхгүй байна. Бодит байдал дээр нэг ч хүнийг зургаан сараас дээш хугацаагаар саатуулаагүй ч энэхүү хуулийн заалтыг олон улсын хүний эрхийн хууль тогтоомжид нийцүүлэхийг Ажлын хэсэг Засгийн газарт санал болгож байна. Түүнчлэн гадаадын иргэдийг саатуулах байрыг эрүүгийн хэргээр шийтгэгдэн ял эдлүүлэх байгууллагаас өөр байранд байрлуулах нь чухал гэдгийг Ажлын хэсэг сануулж байна.

2022 оны есдүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн ОХУ-д хэсэгчилсэн дайчилгаа зарласнаас хойш Монгол Улс ОХУ-ын иргэдийн томоохон шилжилт хөдөлгөөнтэй тулгараад байна.. ОХУ-ын иргэд Монгол Улсад 30 хоногийн хугацаанд тусгай зөвшөөрөлгүй нэвтрэх тул тэдгээр иргэд чөлөөтэй ирж, эхний 30 хоног өнгөрсний дараагаар тэдний статусыг хууль ёсны болгоход туслах зорилгоор, тухайлбал янз бүрийн төрлийн виз олгох, тэр ч байтугай түр оршин суух зөвшөөрөл олгох зэрэг хэд хэдэн зохицуулалтыг хийсэн байна. Сүүлийн үеийн цагаачлалын нөхцөл байдлын улмаас Оросын нэг ч иргэн саатуулагдаагүй байна. Энэ талаар Засгийн газраас баримталж буй чиг хандлагыг Ажлын хэсэг сайшааж байна.

Өндөр настнуудыг халамжлах

Ажлын хэсэг Төв аймгийн Батсүмбэр сум дахь Ахмадын үндэсний төвийн үйл ажиллагаатай танилцлаа. Тус төв нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2013 оны А-157 дугаар тушаалаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг тусламж дэмжлэг шаардлагатай иргэдийг улсын асрамжийн газарт хэвтэн эмчлүүлэх асуудлыг зохицуулдаг болохыг мэдээлэв. Тус төвд хамрагдан асрамжлуулах нь сайн дурын үндсэн дээр явагдах бөгөөд хэрэв асрамжлуулах өргөдлийг асран хамгаалагч гаргасан бол асрамжид хамруулахын тулд ахмад настны өөрийн зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай байдаг. Мөн хэрэв асрамжлуулагч өөрөө хүсэлт гаргавал тэрээр хүсэлтийнхээ дагуу асрамжийн газрыг орхин явах нь бүрэн чөлөөтэй байдаг байна. Уг асрамжийн газрыг Ажлын хэсэг эрх чөлөөгөө хасуулах газар биш гэж дүгнэж, сайн дурын үндсэн дээр асрамжлуулах арга барилыг сайшаан тэмдэглэж байна.

Монгол Улс ахмад настны халамж асрамжийн асуудлаар хууль тогтоомж, бодлогын эерэг арга хэмжээ авч байгаа хэдий ч цаашид анхаарах шаардлагатай зүйлүүд байгааг Ажлын хэсэг тэмдэглэж байна. Тухайлбал санхүү, нийгмийн баталгаа багатай алслагдсан нутагт ажиллах ажилтны нөөц дутагдалтай байдаг байна. Барилга байгууламжийн хэмжээ нь том учраас ажилтнууд нь бусад орчинд ажиллаж байсан хамт олонтой харьцуулахад ажлын ачаалал ихтэй байна. Хэдийгээр ажилтнуудын тууштай байдал нь сайшаалтай ч энэ нь тогтвортой биш бөгөөд системчилсэн, стратегийн арга барил шаардлагатай. Монгол Улсын Засгийн газарт тухайлбал 2021 оны Хөдөлмөрийн тухай хуулийн ажлын байрны мэргэшлийн тогтолцооны дагуу асрамж, халамжийн байгууллагын нөхцөлд гүйцэтгэсэн ажлын нөхцлийг “хүнд” гэж тооцох, холбогдох стратегийн бодлого, удирдамжийн залгамж

чанарыг хангах замаар бэрхшээлийг шийдвэрлэхийг санал болгож байна. Түүнчлэн асрамж, халамж шаардлагатай өндөр настнуудыг цөөн цөөнөөр цомхон жижиг хэмжээтэй байранд байрлуулж тусламж, халамж үзүүлэх бололцоог судлах санал дэвшүүлж байна.

Ш. Үндсэн дүгнэлтүүд

2017 оны Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн (ЭХХШТХ) шинэчилсэн найруулга

Монгол Улс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд баталж, иргэнийг баривчлах, цагдан хорих тогтолцоогоо олон улсын хүний эрхийн хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагатайгаа уялдуулах зорилготой хэд хэдэн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна. Шинэчлэгдсэн ЭХХШТХ-ийн дагуу цагдаагийн байгууллагад сэжигтнийг цагдан хорих хугацаа 6 цагаас илүүгүй байна гэж заасан. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах дээд хугацаа 72 цаг байсныг 48 цаг болгон бууруулсан нь сайшаалтай¹. Цаашилбал, баривчлах ажиллагаа явагдсаны дараа цагдан хорьсон байгууллага нь прокурорт нэн даруй мэдэгдэх² бөгөөд прокурор сэжигтнийг үргэлжлүүлэн хорих талаар шүүхээс зөвшөөрөл авах ёстой. Баривчилснаас хойш 48 цаг дуусч, сэжиглэгдэж байгаа хүнд цагдан хорих шүүхийн шийдвэр ирээгүй бол баривчлах байрны дарга холбогдох байгууллагад мэдэгдэж, түүнийг суллана³. Сэжигтнийг цагдан хорих тухай шүүгчийн шийдвэр нь оргон зайлах эрсдэл, нотлох баримтыг өөрчлөх, хүмүүст хохирол учруулах болон бусад хуульд дурьдагдсан шалтгаан зэрэг бодитой үндэслэлд суурилсан байх ёстой⁴. Өмнөх хуулиар шүүгчид нь шүүх хуралгүйгээр үргэлжлүүлэн хорих шийдвэрийг гаргадаг байсан бол одоо сэжигтэн, өмгөөлөгч, прокурорыг байлцуулан шүүх хуралдааныг явуулдаг байхаар хуульд зааж өгсөн байна. Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүнийг баривчилсан, саатуулсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 13.9-д зааснаар түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж, торгох, нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар хорих шийтгэл ногдуулдаг.

Монгол Улсын хууль эрхзүйн тогтолцоонд хийсэн эдгээр өөрчлөлтийг Ажлын хэсэг сайшааж байна. Хуульд өөрчлөлт орсноор сэжигтэн нь цагдан хорих үндэслэлийг учир утгатайгаар эсэргүүцэх, дур зоргын баривчилгаанаас зайлсхийх боломж нэмэгдсэн байна. Эдгээр шинэчлэл хийгдсэн, мөн олон тооны хоригдлуудад өршөөл үзүүлсэн зэрэг нь урьдчилан хорих ангид хоригдож буй хүмүүсийн нийт тоо цөөрөхөд нөлөөлсөн байна.

2017 оны ЭХХШТХ-ийн шинэчилсэн найруулга нь эерэг өөрчлөлтүүдийн дагуулсан хэдий ч хэрэгжилтийн явцад эрүүгийн эрх зүйн тогтолцооны зарим хэсгүүдийн үйл ажиллагаанд учир дутагдал байгаа нь Монгол Улсад олон улсын хүний эрхийн хуулийг дагаж мөрдөх ажилд сөрөгөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Цагдаа нар анхнаасаа иргэдийг цагдаагийн хэлтэс рүү гэрчээр дуудах нь хэвийн үзэгдэл бөгөөд дуудагдсан хүмүүс үнэн хэрэгтээ чөлөөтэй явах эрхгүй байдаг тухай Ажлын хэсэг олон хүнээс сонссон. Ийм нөхцөлд цагдаагийн хэлтэст бүтэн өдрийг өнгөрөөж байсан боловч энэ хугацааг зөвшөөрөгдсөн 6 цаг болон 48 цагт албан ёсоор тооцон оруулдаггүй гэж тэд мэдээлж байв. Цагдаагийн газарт тухайн хүнээс мэдүүлэг авах үед тавьж буй асуултуудаас нь түүнийг сэжигтнээр тооцож байгаа нь тодорхой болдог ч, хүмүүсийг гэрчээр мэдүүлэг өгнө үү хэмээн дууддаг байна. Үүнээс болж сэжигтэн нь өмгөөлөгчтэй зөвлөлдөх, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх зэрэг чухал хамгаалалтаа ашиглаж чадахгүй байж болзошгүй юм. Цаашилбал, тухайн хүн цагдаагийн хэлтэст зөвшөөрөгдсөн 6 цагийн турш албан ёсоор

¹ НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл, 2014 оны 35 дугаар Ерөнхий тайлбар зөвлөмж

² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 30.9

³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 31.12.2

⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 31.4

хоригдсон бол тухайн 6 цаг нь 48 цагийн хугацаанд тооцогддоггүй. Бодит байдал дээр дийлэнх тохиолдолд цагдаагийн албадан саатуулах хугацаа нь зөвшөөрөгдсөн дээд хэмжээ буюу 48 цагаас илт давж байсныг Ажлын хэсэг онцлон тэмдэглэж байна.

ЭХХШТХ-ийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсноос хойш таван жил өнгөрч байгаа хэдий ч ийм зөрчил дутагдал гарсаар байгаа тухай удаа дараа дурьдагдсан тул Засгийн газраас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилтийг яаралтай байдлаар шалгаж үзэхийг Ажлын хэсэг хүсч байна.

Цагдаагийн байгууллагад хоригдох

Сэжигтнүүдээс цагдаагийн газрын мэдүүлэг авах өрөөнд мэдүүлэг авч байгаа тухайд сэжигтнүүд ихэвчлэн мэдүүлэг өгсний дараа явах эрхгүй байдаг талаар Ажлын хэсэг мэдээлэл авсан. Мэдүүлэг авсны дараа тэднийг ихэвчлэн албан ёсоор баривчилж, цагдан хорих байр луу шилжүүлдэг. Олон улсын хүний эрхийн хуулинд “хүн өөрийнх нь сайн дурын зөвшөөрөлгүйгээр саатуулагдсан”⁵ тохиолдолд тухайн хүний эрх чөлөөг нь хассанд тооцдог. Эрх чөлөөгөө хасуулах явдал нь хаана ч тохиолдож болох бөгөөд үүнийг албан ёсоор баривчлах, түр саатуулах гэж үзэх эсэхээс үл хамааран, ийм тохиолдолд дур зоргоор саатуулагдахаас хамгаалагдах нөхцөл бүрдэнэ. Эрх чөлөөгөө хасуулсан хугацаа нь цөөн цаг байсан ч, үргэлжлэх хугацаанаас үл хамааран, үүнийг саатуулсанд тооцно. Монголын нөхцөлд хэрэв сэжигтэн мэдүүлэг өгөх үйл ажиллагаанаас гарах эрхгүй бол тухайн сэжигтэн цагдаагийн хэлтэс дээр ирж, тухайн мөрдөгчийн хяналтад орсон мөчөөс хойш саатуулагдсанд тооцогдоно. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу мэдүүлэг авах өрөөнүүд дүрс, дууны бичлэг хийхээр тоноглогдсон байх ёстой байдаг ба энэ нь зүй бус харьцах, эрүүдэн шүүх зэрэг ноцтой зөрчлөөс урьдчилан сэргийлэх чухал хүчин зүйл болдог. Гэсэн хэдий ч энэ нь олон улсын хүний эрхийн хуулийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бүрэн эрхээ эдлэх хангалттай боломжийг сэжигтэнд олгож чадахгүй байна.

Мэдүүлэг авах өрөөнөөс гадна Ажлын хэсэг өөр хоёр төрлийн саатуулах газартай танилцлаа. Энэ нь цагдаагийн хэсгийн дэргэдэх эрүүлжүүлэх байр ба зөрчлийн (жижиг) хэрэг үйлдэж “баривчлах” шийтгэл авсан этгээдүүдийг 30 хүртэл хоног саатуулах байр юм. Хэдийгээр эдгээр газрууд Монгол Улсын тодорхой хууль эрх зүйн хүрээнд зохицуулагддаг боловч аль аль нь хүний эрх чөлөөг хасах шинж чанартай тул дур зоргоор саатуулахтай холбоотой олон улсын хүний эрхийн хууль тэнд үйлчилнэ. Хамгийн гол нь түр хоригдсоноос хойш 48 цагийн дотор шүүхээр хянуулах эрх нь эрх чөлөөгөө хасуулсан мөчөөс эхлэн хэрэгждэг ба хоригдогчийг нэг төрлийн байрнаас нөгөө рүү шилжүүлсэн тохиолдолд уг хугацаа шинээр тоологдож эхлэхгүй. Зөрчил гаргасан хүнийг эхлээд эрүүлжүүлэх байранд албадан эрүүлжүүлээд, дараа нь цагдаагийн мэдэлд шилжүүлсэн тохиолдолд хүндрэлтэй асуудал үүсдэг гэдгийг Ажлын хэсэг тэмдэглэж байна. Учир нь хүнийг эрүүлжүүлэх байранд 24 цаг хүртэл хугацаагаар байлгаж болдог, харин цагдаагийн хэлтсийн түр хорих байранд 48 цаг хүртэл саатуулж болдог. Ийм тохиолдолд тухайн хүнийг эрүүлжүүлэх байрнаас цагдаагийн хэлтэс рүү шилжүүлэхдээ хугацааг (48 цагийг) шинээр тооцож эхэлдэг нь хэвийн үзэгдэл болсон бөгөөд энэ нь бодит саатуулах хугацааг зөвшөөрөгдсөн 48 цагаас хэтрүүлэх нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Үүнээс гадна, шүүгчид амралтын өдрүүдээр ажилладаггүй учир хэрэв тухайн этгээд Баасан гарагт саатуулагдсан бол 48 цагийн хязгаарлалтыг дагаж мөрдөхөд хүндрэл үүсдэг байна. Энэ байдлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай.

Ажлын хэсэг хэд хэдэн байршилд үйл ажиллагаа явуулж буй эрүүлжүүлэх байртай танилцсан ба эдгээр байрууд ерөнхийдөө энгийн боловч эрүүл мэндийн үзлэг хийх зэрэг тодорхой зориулалтын өрөөнүүдтэй болохыг тэмдэглэсэн. Саатуулагдсан этгээдүүдийг зөвшөөрөгдсөн дээд хязгаар болох 24 цагийн дотор суллаж, эрүүл мэндийн үзлэгт

⁵ A/HRC/36/37, para 51. See also CCPR/C/GC/35at para. 5

хамруулж, тэмдэглэл хөтөлдөг болох нь бүртгэлийн дэвтрээс харагдсан ба бүх эрүүлжүүлэх байранд хяналтын камерууд ажиллаж байсан. Гэвч долоо хоног хүртэл дарааллан үргэлжилдэг тодорхой улсын баяр ёслолын үеэр саатуулагдсан этгээдүүдийг зарим эрүүлжүүлэх байранд 24 цагаас илүү хугацаанд байлгасан, мөн ЛГБТИ хүмүүс хэл ам, бие махбодийн хүчирхийлэлд өртөх тохиолдол цөөнгүй гардаг тухай Ажлын хэсэг олж мэдсэн ба үүнд санаа зовж байна. Тухайн этгээд эрүүлжүүлэх байранд саатуулагдах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу явагддаггүй тул эрүүлжүүлэх байрууд шийтгэх арга хэрэглэхээс зайлсхийх нь чухал. Мөн эрүүлжүүлэх байруудад хэл ам, бие мах бодийн хүчирхийлэл үйлдэхийг бүрмөсөн хориглож, буруутай албан хаагчид хариуцлага тооцдог байх шаардлагатай.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба Шударга шүүхээр шүүлгэх эрх

Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах тохиолдол нэн өндөр хувьтай байгаад Ажлын хэсэг туйлын ихээр санаа зовж байгаагаа тэмдэглэв. 2020 онд баривчлах ажиллагааны 99.3 хувь нь шүүхийн шийдвэргүйгээр хийгдсэн бол 2021 онд энэ үзүүлэлт 98.3 хувь болжээ. Баривчлах ажиллагааны маш өндөр хувь нь шүүхийн урьдчилсан хяналтгүйгээр явагдаж байгаа нь олон улсын өмнө Монгол Улсын хүлээсэн хүний эрхийн талаарх үүрэг хариуцлагатай огт нийцэхгүй гэж Ажлын хэсэг үзэж байна. Хэдийгээр 2017 оны ЭХХШТХ-ийн дагуу ийм тохиолдолд 48 цагийн дотор шүүхээс заавал зөвшөөрөл авахыг шаарддаг ч баривчлах зохих үндэслэл байгаагүй бол тухайн хүний эрх аль хэдийн хохирсон байх болно. Ялангуяа Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар зэрэг мэргэжлийн байгууллагууд шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчлах явдал газар авч байгаад Ажлын хэсэг онцгойлон санаа зовж байна. Эдгээр байгууллагуудын мөрдөн байцаалтын ажлын онцлогийг харгалзан үзвэл дийлэнх тохиолдолд шүүхээс зөвшөөрөл авахгүй байх нь төсөөлшгүй юм. Хүнийг өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр баривчлахыг олон улсын хүний эрхийн хуулийн дагуу зөвхөн онцгой, онцгой нөхцөлд, тухайлбал сэжигтэн илэрсэн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд л зөвшөөрдөг боловч цагдан хорих үйл явцын таамаглалын хэм хэмжээ хэзээ ч байж болохгүй. Үүнийг Засгийн газар яаралтай шийдвэрлэх ёстой.

Мөн Монгол Улсад мөрдөн шалгалтын, хяналтын прокурорын, шүүхийн зэрэг бүх шатанд яллагдагч гэм буруугаа хүлээн зөвшөөрөх явдал чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг Ажлын хэсэг анзаарсан. Жилд 12,000-13,000 хэрэг шийдвэрлэгдэж байгаагийн 40 орчим хувьд нь яллагдагч хэргээ хүлээсэн байна. Ихэнх орны эрх зүйн тогтолцооны Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэм буруугаа хүлээсэн мэдүүлгийг ашиглах нь түгээмэл явдал ба энэ нь асуудал биш юм. Гэхдээ бодитой баримтыг тогтоох зорилгоор зохих мөрдөн шалгах ажиллагаа явуулахын оронд ялтнаар хэргийг хүлээлгэх аргыг байнга ашиглаж болохгүй. Сэжигтнүүдийн хүсэл зоригийг мохоож, дарамт шахалт үзүүлэн, заналхийлэх, айлган сүрдүүлэх замаар хэрэг хүлээлгүүлэх тохиолдол олонтаа гарч байгаад Ажлын хэсэг санаа зовж байна. Ийм үйл ажиллагаа нь олон улсын хүний эрхийн хуулийг зөрчиж байгаа бөгөөд 2021 онд Ажлын хэсгийн баталсан Хууль сахиулах байгууллагын мөрдөн шалгах үйл ажиллагаандаа баримтлавал зохих “Мендезийн зарчим”-д нийцэхгүй.⁶

Үүнтэй холбоотойгоор хөнгөн гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг ашиглаж байна. Хэрэв гэмт хэрэг нь 8 ба түүнээс дээш жилийн хорих ялтай бол эрүүгийн хэрэг үүсгэж, хэргийг шүүхээр хэлэлцүүлэх ёстой. Эсрэгээр, хэрэв гэмт хэргийн ялын дээд хэмжээ 8-с доош жил байвал, мөн сэжигтэн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн нөхцөлд хэргийг "хялбаршуулсан журмаар" хянан шийдвэрлэж болно. Дахин хэлэхэд, хялбаршуулсан журам байгаа нь хүний эрхийн хэм хэмжээнд харшлахгүй. Үнэн хэрэгтээ энэ нь эрүүгийн эрх зүйн тогтолцооны үр ашгийг нэмэгдүүлэх, шүүхийн ачааллыг бууруулах хэрэгсэл болж чадна. Хэдий тийм ч тогтолцоонд үр өгөөжтэй гээд хувь хүмүүсийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хохироож болохгүй. Ялангуяа, хэргийг

⁶ A/HRC/51/29, paras. 53- 55.

"хялбаршуулсан журмаар" хянан шийдвэрлэх боломжийг сэжигтний хүсэл зоригийн эсрэг хэрэг хүлээлгэх, албадах зорилгоор ашиглахгүй байхыг Засгийн газар баталгаажуулах ёстой.

Монгол Улсын хуулиар сэжигтэн гэм буруугаа хүлээхээс өмнө хууль зүйн туслалцаа авах эрхтэй ба, баривчлах ажиллагаа явуулсан албан тушаалтнууд баривчлагдсан хүмүүст хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх бүрэн эрхийг нь ("Миранда" эрх) мэдэгдэх үүрэгтэй ч мөрдөгчид сэжигтнүүдийг тогтмол дарамталж, айлган сүрдүүлж, гэрчээр өгсөн мэдүүлгийг ашиглан хэрэг хүлээлгэх арга хэрэглэдэг тухай өмгөөлөгчид болон хоригдлууд Ажлын хэсэгт мэдэгдсэн. Тиймээс олон хүн өмгөөлөгчтэй уулзахаасаа өмнө хэрэг хүлээдэг байна. Хууль сахиулах байгууллагын ажилтнууд сэжигтнийг баривчилсны дараа тэдэнд хууль зүйн туслалцаа авах эрхийг тайлбарлаж, энэ эрхийг нь зохих ёсоор хүндэтгэн, өмгөөлөгч авахад нь туслалцаа үзүүлэх ёстой. Мөрдөгч өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр сэжигтнээр хэргийг нь хүлээлгэсэн тохиолдолд шүүх үүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах ёсгүй.

Хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх тодорхой хугацааг хууль эрхзүй, зохицуулалтын хүрээгээр тогтоосон байдаг. Гэсэн хэдий ч мөрдөгчид, прокурорууд, шүүгчдийн ажлын ачаалал хэт их байгаагаас тэд хуулиар тогтоосон хугацаанд тэр бүр амждаггүй, хэрэг тус бүрийг нарийвчлан авч үзэх боломж хязгаарлагдмал байдаг байна. Түүгээр ч зогсохгүй мөрдөн байцаагч, прокурор нарыг хянан шийдвэрлэсэн хэргийнх нь тоогоор өрсөлдүүлж, сар бүрийн эцэст "ялагч"-ийг зарлаж, цалингийн болон бусад урамшуулал өгдөг практик тогтсон байна. Бодит байдал дээр ийм уралдаан өрнөдөг учраас мөрдөгчид болон прокурорууд зорилтот түвшиндээ хүрэхийн тулд яаравчилж, хэргийг нарийвчлан шалгадаггүй нь тэдний ажлын чанарыг мэдэгдэхүйц бууруулахаас гадна, иргэдийн эрх чөлөөг дур мэдэн хасах явдалд хүргэж болзошгүй юм. Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтийг Засгийн газарт танилцуулсны дараа Улсын Ерөнхий Прокурорын газар болон Тагнуулын Ерөнхий газраас дээр дурдсан практик үйл ажиллагаа зогссон гэдгийг Ажлын хэсэгт мэдэгдэв.

Үүнээс гадна, өмгөөлөгч нар үйлчлүүлэгчийнхээ урьдчилан хорих үндэслэлийг эсэргүүцэж мэтгэлцэхээс өмнө хавтаст хэрэгтэй бүрэн танилцах боломжгүй байгаад Ажлын хэсэг санаа зовж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1-д мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа өмгөөлөгч хавтаст хэрэгтэй бүрэн танилцах боломжтой гэж заасан байдаг. Гэтэл бодит амьдрал дээр урьдчилан хорих шийдвэрийг ихэвчлэн мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байх үед гаргадаг. Энэ заалтыг өмгөөлөгч нарт хавтаст хэрэгтэй танилцахыг бүрмөсөн хориглох зорилгоор ашиглаж байгаа нь өмгөөлөгч нарт үйлчлүүлэгчийнхээ урьдчилан хорих үндэслэлийг эсэргүүцэхэд ихээхэн саад учруулж байна. Урьдчилан хорих үндэслэлийн нотлох баримттай танилцах боломжгүйн улмаас өмгөөлөгчид "таамаглал дэвшүүлж", "харанхуйгаар" эсэргүүцэх ёстой болдог тухай Ажлын хэсгийнхэн мэдсэн.

Ихэвчлэн хэрэг прокурорт шилжих өдөр л өмгөөлөгчид хавтаст хэрэгтэй танилцах зөвшөөрлийг өгдөг ба энэ тухай цагийг нь нэлээд тулгаж мэдэгддэг. Өмгөөлөгч нь мөрдөн байцаагчийн өрөөнд цаг алдалгүй очсон байсан ч материалыг хуулбарлах, тэр ч байтугай зургийг нь авахыг хориглодог тул өмгөөлөгчид боломжийнхоо хэрээр хавтаст хэргийн агуулгыг гараар тэмдэглэн авах ёстой болдог байна.

Жишээлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.1-д заасны дагуу шинжээчийн дүгнэлтийг зөвхөн мөрдөгч, эсхүл прокурор гаргаж болдог. Тиймээс практик дээр өмгөөлөгчид шүүхийн үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг болох шинжээчийн дүгнэлтийг шаардах боломжгүй байдаг нь өмгөөллийг сул тал болгож, шүүхийн хэлэлцүүлгийн явцад яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явуулах нөхцөл бүрдэхгүй байна.

Өмгөөлөгчийн шүүх хуралдаанд оролцож, үйлчлүүлэгчийнхээ эрхзүйн байдлыг хамгаалах эрх нь хазгаарладагаас гадна шүүх хурал нь ихэвчлэн тун богино хугацаанд болдог байна.

20 хүртэлх жилийн ялтай онц хүнд гэмт хэргийг шүүх хурал ч нэг цаг хүрэхгүй хугацаанд болж өнгөрдөг. Ажлын хэсэг өмгөөллийн эрхийг зохих ёсоор хангуулах, өмгөөлөгч нар үйлчлүүлэгчээ бодитой төлөөлөхөд нь хангалттай цаг хугацаа, нөөц бололцоо, ялын үндэслэл болсон материалыг олж авах боломжийг бүрдүүлэхийг Засгийн газраас хүсч байна.

Энэ бүхэн нь талуудын тэгш байдлын зарчмыг ноцтой зөрчсөн, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9, 14 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын хүлээсэн үүрэгт нийцэхгүй байгаагийн жишээ юм.

Хорих байгууллагууд

Монгол Улсад ял шийтгүүлсэн хоригдлууд нээлттэй, хаалттай хорих анги, эсвэл улсад ганц байдаг хаалттай /тусгай нэгж/ гэсэн гурван төрлийн хорих ангид ял эдэлдэг. Ялтнуудыг зөвхөн ял оногдуулсан шүүхийн шийдвэрт үндэслэн хорих анги руу шилжүүлдэг бөгөөд хяналт шалгалтын явцад үндсэн хорих ангиудад урьдчилан саатуулагдсан хүн байгаагүйг Ажлын хэсэг сайшаан тэмдэглэж байна.

Нээлттэй дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдлууд ажлын байраар хангагдаж, цалин хөлс авч байгаа явдлыг Ажлын хэсэг сайшааж байна. Хорих ангийн дэг журмыг чанд сахиж, хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлсэн, өөрийн зан үйл, хувийн байдлаараа эерэг үнэлгээ авсан хоригдлыг урамшуулдаг буюу ял эдлэх 30 хоног тутам 40 хоногийг ял эдэлсэнд тооцдог “шагналын хоног” гэж нэрлэгддэг тогтолцоо нь бүр ч сайшаалтай юм. Улмаар хоригдол нэг жилд 120 хүртэлх “шагнал”-ын хоног хуримтлуулах боломжтой бөгөөд ингэснээр түүний биеэр эдлэх ялын хэмжээ нь багасна гэсэн үг юм. Гэсэн хэдий ч, шагналын хоногийг сахилгын зөрчил гаргасан тохиолдолд хасаж болох бөгөөд энэ талаар албан ёсны журам байдаггүй тул шагналын хоногийг дур мэдэн хасаж байгаад Ажлын хэсэг ихээхэн санаа зовж байна.

Түүгээр ч барахгүй хоригдлууд маш хатуу дэглэмд захирагддаг ба зарим шаардлагыг нь доромжлол, хүнлэг бус хандлага гэж ойлгож байна. Тухайлбал, бүх хорих ангиудад хоригдлууд болон хянагч нарын хоорондын зайг зааглахын тулд ялтны өрөө тус бүрээс нэг метрийн зайтай улаан зураас зурсан байдаг. Хоригдлуудад энэхүү улаан шугам дээр гишгэхийг хориглодог тул тэд үргэлж хана даган алхах ёстой гэсэн үг юм. Хоригдлуудад шугам давах тоолонд нь шийтгэл ногдуулна гэж байнга сануулдаг ба ихэвчлэн хуурамчаар улаан шугам дээр гишгэсэн хэмээн шийтгэх арга болгож ашигладаг гэж олон хоригдол ярьж байсан. Ажлын хэсгийн гишүүдтэй уулзсанахаа төлөө “шагналын хоног”-оо хасуулах зэргээр хэлмэгдэхээс болгоомжилж, хоригдлууд бидэнтэй уулзахаас татгалзаж байсанд Ажлын хэсэг онцгойлон санаа зовниж байна. Шагналын хоног” гэж нэрлэгдэх хугацааг хасаж байгаа одоогийн хандлагыг өөрчилж, албан ёсны болгож, хууль бусаар ашиглах боломжийг бүрмөсөн арилгахыг Ажлын хэсэг Засгийн газраас шаардаж байна. Хоригдлуудад улаан шугамыг давж гарахыг хориглодог практикийг нэн даруй халах ёстой. Ажлын хэсэгтэй ярилцсан хоригдлуудаас хэнийг ч хэлмэгдүүлэхгүй байхад хяналт тавихыг Засгийн газарт уриалж байна.

Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.12-т заасан Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох механизмтай Ажлын хэсэг танилцсан. Ажлын хэсгийн очиж танилцсан бүх хорих ангиудад ялтнуудыг хугацаанаас нь өмнө суллах санал гаргадаг Арга зүйн зөвлөл байдгийг нааштайгаар тэмдэглэж байна. Дээр дурдсан “шагналын хоногийн” тогтолцоо нь зарчмын хувьд биеэр эдлэх ялын хугацааг мэдэгдэхүйц багасгах боломжийг хоригдлуудад олгож байна. Гэсэн ч ямар нэгэн тайлбар өгөлгүйгээр хугацаанаас нь өмнө суллах асуудлаар хоригдлыг Арга зүйн зөвлөлийн хурлаар оруулахаас татгалзсан тохиолдол гарч

байсан байна. Арга зүйн зөвлөлөөс шийдвэр гаргах талаар албан ёсны бөгөөд ил тод журам байхгүй байгаад Ажлын хэсэг санаа зовж байна. Засгийн газар Арга зүйн зөвлөлийн үйл ажиллагааг цаг алдалгүй хянаж, холбогдох журмыг албажуулах, шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг хангуулах нь зүйтэй.

Өөр нэг санаа зовоосон асуудал бол хорих ангиудад хэрэгжиж буй амиа хорлох явдлыг хянах протокол буюу амиа хорлох эрсдэлтэй хоригдлын гарыг гавлаж байгаа асуудал юм. Амиа хорлох эрсдэлтэй хоригдлын гарыг гавлаж байлгах хугацаанд дээд хязгаар байхгүй ба хянагчид гар гавыг 15-20 минутын зайтай шалгах үүрэгтэй байна. Үүний нэгэн адил ялтнуудыг хорих ангиудын хооронд шилжүүлэхдээ гав хэрэглэдэг бөгөөд Монгол Улсын газарзүйн байршлын онцлогийг харгалзан үзвэл хоригдлыг тээвэрлэхэд бүтэн өдрийг ч зарцуулж болно. Иймээс, ялтнуудыг, тэр дундаа насанд хүрээгүй хүүхдүүдийг гавлаж, суудлын бүс зүүлгэхгүй микроавтобусаар (эсвэл ачааны/фургон тэргээр) тээвэрлэх явцад тэд гэмтэх эрсдэл өндөр байна. Ажлын хэсэг энэхүү практикийг нэн даруй хянаж үзэхийг уриалж байна.

Зарим хорих ангиудад хорих ангийн нөхцлийг сайжруулах чиглэлээр тодорхой хүчин чармайлт гаргаж байгааг Ажлын хэсэг тэмдэглэж байна. Гахдээ Ажлын хэсгийн очиж танилцсан бүх хорих ангиудад ялтнуудад долоо хоногт нэг л удаа махтай хоол өгдөг, бусад өдрүүдэд малын гэдэс цувдайтай хоол өгдөг талаар бидэнд байнга мэдээлж байв. Хоригдлуудад өгч буй хоолны тэжээллэг чанар муу байгаад Ажлын хэсэг санаа зовниж байна. Ажлын хэсэг Засгийн газраас эдгээр асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэж, ялангуяа Хоригдолтой харьцах тухай Нельсон Манделагийн дүрмийн 22 дугаар заалтын хэрэгжилтийг хангах ажиллахыг уриалж байна.

405 дугаар хаалттай /тусгай нэгж/ хорих анги

Бүх насаар хорих ял шийтгүүлсэн болон сахилгын болон хэв журмын зөрчил гаргасны улмаас нэг жилийн хугацаагаар шийтгэгдэж бусад хорих ангиас шилжиж ирсэн ялтнууд байдаг 405 дугаар хаалттай /тусгай нэгж/ хорих ангид Ажлын хэсэг очиж танилцсан. Энэ хорих ангийн дэглэм онцгой чанга бөгөөд ялтныг ганцаарчилсан тасалгаанд хорьдог. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн ялтан энэ дэглэмд хамгийн багадаа 15 жил хоригдох ёстой. Хүний эрхийн зөвлөлөөс 2017 онд Монгол Улсад өгсөн зөвлөмжийг эргэн санаж, Засгийн газар энэ дэглэмийг яаралтай шинэчлэн боловсруулж, тус байгууламжид ганцаарчлан хорих арга хэмжээг Пактын заалтууд болон Нельсон Манделагийн дүрмүүд, тухайлбал Дүрмийн 43(1) (б) ба 44-р заалтуудад нийцүүлэх ёстой.

Хэдийгээр олон тооны харуул, төмөр тор, хяналтын камертай ч хоригдлууд гар, хөлний гавгүйгээр хаашаа ч хөдлөх боломжгүй байгаа байдлыг хараад Ажлын хэсгийнхэнд бухимдал төрсөн. Хоригдлууд гэр бүлтэйгээ цахимаар уулзалт хийх өрөө болон номын санд хөлний гавыг шалан дээр бэхэлсэн байхыг олж харсан нь сэтгэл их түгшээсэн. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос Монгол Улсад 2017 онд өгсөн зөвлөмжийг эргэн санаж, эдгээр зохицуулалтыг нэн даруй зогсоохыг Ажлын хэсэг уриалж байна.

Эцэст нь, Хаалттай тусгай ангид сахилгын шийтгэл авсны улмаас хоригдож буй хүмүүс ажиллах боломжгүй, улмаар "шагналын хоног" тооцуулж, хугацаанаас өмнө чөлөөлөгдөх эрхээ эдлэх боломжгүй байгаа нь Манделагийн дүрмийн 4-р зарчимд харшилж байгааг Засгийн газар яаравчлан залруулах шаардлагатай байна.

Ерөнхийдөө 405-р хаалттай тусгай нэгж хорих ангид хоригдож буй ялтнуудад дарамт шахалт үзүүлж, шийтгэлийн чанартай харьцаж байгаад Ажлын хэсэг бухимдаж байна. Манделагийн дүрмийн 5-рт заасны дагуу шоронгийн дэглэм нь шоронгийн амьдрал ба эрх чөлөөний амьдралын хоорондох аливаа ялгааг багасгахыг хичээх ёстой. Засгийн газар 405-

р хаалттай тусгай нэгж хорих ангид хоригдож буй хүмүүсийн дэглэм, тэдэнд хандаж буй хандлагаыг яаралтай өөрчлөх хэрэгтэй.

Тухайлсан зарим үйлдлийг гэмт хэрэгт тооцох

Ажлын хэсэг үндэсний хууль тогтоомжийн хэд хэдэн зүйл заалтад хүний эрх чөлөөг дур зоргоороо хязгаарлаж байгаа нь олон улсын эрх зүйн шаардлагад бүрэн нийцэхгүй байгааг тэмдэглэж байна.

Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д заасан Хүнийг хүчээр алга болгох бие даасан гэмт хэргийг оруулж өгснийг сайшааж байна. Гэсэн хэдий ч уг гэмт хэргийн тухай ойлголт, тодорхойлолт нь зөвхөн “хууль бусаар саатуулах” гэсэн утгыг агуулж байгаа тул хүний эрх чөлөөг дур зоргоороо хязгаарлах бүх хэлбэрийг агуулаагүй ба хүчээр алга болгох гэмт хэрэг нь хүний эрх чөлөөг хууль ёсны дагуу хязгаарлаж, улмаар гэмт хэргийн бусад шинж тэмдэг илэрсний улмаас хууль бус болж болно гэдгийг НҮБ-ын Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай хорооноос тэмдэглэж байна.

Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т “Тадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах”, 19.6-д “Хорлон сүйтгэх” гэмт хэрэгт ял шийтгэнэ гэж заасан бол, 13 дугаар зүйлийн 13.14-т гүтгэх гэмт хэргийг оруулсан байна. Ажлын хэсэг эдгээр бүх гэмт хэргүүдийг өргөн утгаар нь тайлбарлаж байгаа бөгөөд тухайлбал, хүний эрх хамгаалагчийн хууль ёсны үйлдлийг болон/эсвэл хувь хүмүүсийн хууль ёсны дагуу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахад ашиглаж болзошгүй гэж болгоомжилж байна. Ажлын хэсэг үүнтэй холбогдуулан стратегийн бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг эсэргүүцсэнтэй холбоотой ямар нэгэн заналхийллийн шинжтэй болон эд хөрөнгөд онц ноцтой хохирол учруулаагүй гэмт хэргээр саатуулагдаж байгаа иргэдийн мэдээллийг хүлээн авсан.

Ойлгомжгүй, өргөн утга агуулгатай хуулиуд нь итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, улс төр, олон нийтийн үйл хэрэгт оролцох, ялгаварлан гадуурхахгүй тэгш байдлыг хангах, үндэс угсаа, шашин шүтлэг, хэлний цөөнхөд хамаарах хүмүүсийн эрх чөлөөг дур зоргоороо хязгаарлах зэрэг хүчирхийлэлд өртөх магадлалтай тул тэднийг хамгаалахад саад учруулж болзошгүйг Ажлын хэсэг сануулж, эдгээр заалтад нэмэлт өөрчлөлт оруулахыг Засгийн газраас шаардаж байна.

Мөн Ажлын хэсэг Ковид-19-ийн тархалтыг зогсоохын тулд дэлхий даяар саяхан гарсан цар тахлын хүрээнд баталсан хууль эрх зүйн хязгаарлалтуудтай танилцсан. Ажлын хэсэг эдгээр хууль эрх зүйн хязгаарлалтууд үйлчлэхээ больсон ч хууль ёсны үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахад эдгээр журам, зохицуулалтыг ашиглаж байгаа талаар олон тооны мэдүүлэг хүлээн авсан.

Түүнчлэн Ковид-19-ийн хязгаарлалтыг эсэргүүцсэн хэргээр саатуулагдаж, баривчлагдсан хүмүүсийн өмгөөлөгчдийг дарамталж, зарим тохиолдолд баривчилсан гэх мэдээлэл байна.

Ковид-19-ийн тархалт зэрэг нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед авч хэрэгжүүлж буй яаралтай хариу арга хэмжээг үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлахад ашиглах ёсгүйг Ажлын хэсэг онцолж байна.

Мөн 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулсан 1994 онд батлагдсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль хуульд бүх төрлийн жагсаал цуглаан хийх гэж байгаа талаараа урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах шаардлагатай байгаа нь үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний хэрэгжилтэд хязгаарлалтын байдлаар ашиглаж болно.

Эцэст нь, Монгол Улсад одоогоор хар тамхи, мансууруулах бодисыг хувийн хэрэгцээнд ашиглах, хадгалах, хэрэглэхийг гэмт хэрэгт тооцдог ба Засгийн газраас энэ хандлагыг эргэн харж, хар тамхи, мансууруулах бодистой холбоотой бодлогод зохих мэргэжлийн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх хандлага баримтлахыг зөвлөж байна.

Зөрчил үйлдсэн тохиолдолд саатуулах

2022 оны Зөрчлийн тухай хуульд зааснаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гэх мэт хөнгөн хэрэг үйлдсэн хүнд 7-оос 30 хоног хүртэл хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах боломжтой байна. Эдгээр саатуулагдсан хүмүүсийг баривчлагдсан этгээд хэмээн нэрлэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа зориулалтын баривчлах байруудад шийтгэлийг эдлүүлдэг. Ажлын хэсэг хэд хэдэн саатуулах байруудаар орж танилцахад харьцангуй дэглэм султай болох нь ажиглагдсан хэдий ч ихэнх саатуулах байранд Монгол Улсын хорих ангиудад хэрэглэдэг улаан шугамыг баривчлагдсан этгээдэд хэрэглэж байна. Энэхүү улаан шугамыг Монгол Улсын бүх саатуулах байруудаар ашиглахыг хориглох нь зүйтэй гэж Ажлын хэсэг дахин давтан хэлье.

Мөн түүнчлэн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байхгүйн улмаас зөрчлийн хэрэгт холбогдогч нь эрүүгийн шүүхээр хэргээ шийдвэрлүүлж байна. Практикт эрүүгийн шүүх нь эрүүгийн хэргийг түрүүнд нь шийдвэрлэж байгаа учраас зөрчилд холбогдогч нь шүүх хурал болох хүртэл дунджаар 4 цаг орчим хүлээх шаардлагатай болж байна. Хүмүүсийг өглөө шүүх хуралдаантай гэж дуудчихаад, хүлээж суух газар ч гаргаж өгөхгүйгээр үдээс хойш хүртэл шүүх хуралдаан нь болохгүй хүлээлгэх нь бараг хэвийн үзэгдэл болсон байна. Гэтэл зөрчлийн хэрэг шийдвэрлэх шүүх хуралдаан нь маш богино буюу 15-20 минутын хугацаанд л үргэлжилдэг. Холбогдогч хууль зүйн туслалцаа авах эрхтэй хэдий ч энэ нь үнэ төлбөргүй биш учраас шүүх хуралдаанд ихэвчлэн хууль зүйн туслалцаа авалгүйгээр оролцож байна. Анхан шатны шүүхийн шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор тухайн шийдвэрт гомдол гаргах боломжтой боловч баривчлах хугацаа нь богино бөгөөд анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу баривчлах шийтгэл оногдуулмагц баривчлагдсан этгээдийг шууд баривчлах байранд аваачиж байгаа учраас шүүхийн шийдвэрт гомдол гаргах тохиолдол практикт ховор байна. Эцэст нь дурдахад баривчлагдсан этгээд эдгээр баривчлах байранд саатуулагдах хугацаандаа өдрийн 3800 төгрөгний төлбөр төлөх үүрэг хүлээж байна. Зарим баривчлагдсан этгээд баривчлах байранд засвар үйлчилгээний ажил хийгээд, ажил хийсэн хугацаандаа баривчлах байрны төлбөрөөс чөлөөлөгдөж байна.

Ажлын хэсэг нь хүний эрх чөлөөг хасах нь хамгийн эцсийн шатанд авах арга хэмжээ байх ёстой гэдгийг сануулаад, Зөрчлийн хуулийн дагуу шийтгэл оногдуулж буй үйлдлүүдийн цар хүрээний хувьд санаа зовниж буйгаа илэрхийлж байна. Пактын 9 дүгээр зүйлд заасны дагуу хүний эрх чөлөөг хангах үүднээс баривчлах шийтгэл оногдуулж буй үйлдлүүдийн цар хүрээг Засгийн газар дахин нэг нягталж үзэх нь зүйтэй. Мөн баривчлагдсан этгээд нь баривчлах байранд саатуулагдсаныхаа төлөө ямар нэгэн төлбөр төлөх үүрэг хүлээхгүй байх нь зүйтэй. Эцэст нь дурдахад хэдий саатуулах хугацаа нь богино байсан ч хүнийг дур мэдэн саатуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд хэрэгжих ёстойг сануулж, зайлшгүй хийгдэх процессын баталгааг, ялангуяа хууль зүйн туслалцаа авах эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэхийг Ажлын хэсэг зөвлөж байна.

Хүүхдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт хүүхдэд буюу өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг зохицуулсан бөгөөд 6.2.1 дүгээр зүйлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг 16 нас гэж, харин 6.2.2 дугаар зүйлд тус зүйлд заасан онц ноцтой хэргийг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг 14 нас байхаар тогтоосон

байна. Монгол Улсад хууль зөрчсөн хүүхдэд саатуулахаас бусад хэд хэдэн төрлийн арга хэмжээг өргөнөөр авч хэрэгжүүлдэг талаар Ажлын хэсэгт мэдээлсэн бөгөөд 16 нас хүрээгүй хүнийг цагдаа цагдан хорьж байсан тохиолдол байхгүй, мөн шүүх хуралдаанаас өмнө хүүхдүүдийг цагдан хорих нь ховор байдаг нь тун сайшаалтай байна.

Гэхдээ шүүхийн системд өсвөр насныхны дагнасан шүүх байхгүй ба Хүүхдийн эрхийн хууль зүйн хороод хүүхдийн хөгжлийн асуудалд хяналт тавих чиг үүрэгтэй ажиллаж байна. Цагдан хорих байранд саатуулагдсан хүүхдэд боловсрол олгох үйл ажиллагаа явуулахгүй байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна. Харин хорих ял эдэлж буй хүүхдүүдийн хувьд нөхцөл байдал өөр бөгөөд тэд Улаанбаатар дахь сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хоригдон сургалт, боловсролын үйл ажиллагаанд хамрагдаж байна. Тухайн тусгай байгууллагад хоригдож байгаа хүүхдүүд сургуулийн дүрэмт хувцас өмсч, сурч боловсрох хүсэл тэмүүлэлтэй байгаа нь харагдсан. Гэхдээ бидний очиж танилцсан тусгай байгууллагын байр нь засвар үйлчилгээ муутай бөгөөд ариун цэврийн өрөөний суултуур, шүршүүр нь эвдэрсэн, сургалтын танхим зай багатай зэрэг асуудлууд ажиглагдсан. Иймд эдгээр хүүхдүүдийг хорьж, саатуулж буй байрны орчин нөхцөлд нэн даруй анхаарал хандуулахыг Ажлын хэсэг зөвлөж байна.

Сэтгэцийн эмгэгтэй хүнийг саатуулах

2000 оны Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийг 2013 онд шинэчлэн найруулж, баталсан бөгөөд тус хуулиар сэтгэцийн эмгэгтэй хүнийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд сайн дурын үндсэн дээр болон албадан эмчлэхтэй холбоотой асуудлуудыг зохицуулсан байна. Хэдий тус төв нь 550 эмчлүүлэгчийн багтаамжтай боловч Ажлын хэсэг очиж танилцах үед тус төвд нийт 552 эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлж байсан бөгөөд амбулаториор үйлчлүүлж буй эмчлүүлэгчдийн тоо ч их байсан. Ихэнх эмчлүүлэгчид нь тус төвд 1 сар орчим эмчлүүлээд гардаг бол 20-25 жил эмчлүүлж буй эмчлүүлэгчид мөн байлаа. Тэдэн дундаас эмнэлгээс гаргах боломжтой 120 хүн байгаа гэдгийг Ажлын хэсэг олж мэдсэн. Гэсэн хэдий ч нийгэм, хамт олонд түшиглэсэн тусламж үйлчилгээ байхгүй, мөн тэдгээр хүмүүсийг харж хандах, тусламж, дэмжлэг үзүүлэх гэр бүл, төрөл садан байхгүй учраас тус төвөөс хэзээ гарах нь тодорхойгүй байсаар байна. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн санаачлагаар 20 гаруй жилийн өмнө ийм нөхцөлд байгаа хүмүүсийг эмнэлгээс гаргаж, тусад нь амьдруулах зорилгоор эмнэлгийн хашаан дотроо Монгол гэр барин зарим эмчлүүлэгчдийг тусад нь гарган, тусгайлсан асрамжийн үйлчилгээ үзүүлсэн нь тун сайшаалтай байна. Цаашид үүнтэй адил асрамжийн үйлчилгээ болон нийгэм, хамт олонд түшиглэсэн тусламж үйлчилгээг илүү өргөжүүлж, Монгол Улсын 21 аймагт нэвтрүүлэхийг Ажлын хэсэг зөвлөж байна.

Гэмт хэрэг үйлдсэн боловч сэтгэцийн эмгэгийн улмаас хэрэг хариуцах чадваргүйд тооцогдсон хүнийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хаалттай тасагт хэвтүүлэн эмчилдэг. Эмнэлгийн орчин нөхцөл нь минималист бөгөөд цэвэрхэн, олон нийтийн цугларах хэсэгтэй, гадаа дасгал хийх талбайтай байсан. Хэрэг хариуцах чадваргүйд тооцогдсон хүнийг тус төвд албадан эмчлүүлэх шийдвэрийг шүүх гаргадаг бөгөөд шүүхээс холбогдох үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж байна. Шүүх хяналт тавьж, тухайн эмчлүүлэгчийг эмнэлгээс гаргах эсэхийг шийддэг боловч энэхүү шийдвэрийг гаргахдаа тус Төвийн эмчийн магадлагааг үндэслэдэг байна.

IV. Дүгнэлт

Эдгээр нь Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтүүд юм. Энэхүү айлчлалтай холбоотой эцсийн дүгнэлтүүдээ гаргахын зэрэгцээ Монгол Улсын Засгийн газартай хийсэн бүтээлч яриа хэлэлцээг ирэх саруудад үргэлжлүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Монгол Улсын Засгийн

газар Ажлын хэсгийг өөрийн оронд урьж ажиллуулсныг бид талархалтайгаар хүлээн авч, энэ нь хүний эрх чөлөөг дур мэдэн хасаж болзошгүй нөхцөл байдлуудыг шийдвэрлэхийн тулд ямар шинэчлэл, өөрчлөлт хийх шаардлагатайг тодорхой болгох боломж гэдгийг тэмдэглэж байна.